



МОНГОЛ УЛСАД ОРЧИН ЦАГИЙН БАНКНЫ ТОГТОЛЦОО ҮҮСЭЖ, БЭХЭЖСЭНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

НЭГ.ЗОРИЛГО

Эдийн засаг, санхүү, хууль зүйн чиглэлээр судалгааг хийдэг судлаач, эрдэмтэд болон оюутнуудыг дэмжих, бүтээлүүдийг нь нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Төв банкны зорилт, засаглал, үйл ажиллагааны чиглэл, эрх зүйн шинэчлэл

ГУРАВ.БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 Бүтээлийн агуулгын хувьд:

- Онол, арга зүйн үндэслэлтэй;
- Шинэлэг, оновчтой санал, санаачлага дэвшүүлсэн;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц;
- **Оюутны ангилалд** оролцох судалгааны ажлууд заавал удирдагч багштай байх;
- Бусдын ажлыг шууд хуулбарлаагүй;
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах);
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан;
- Судалгааны шалгарсан болон шинэлэг арга хэрэгслүүдийг ашигласан байх;
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжид хүрсэн байх.

3.2 Оролцогчийн хувьд:

- Оюутны (бакалавр, магистрын түвшиний оюутнууд энэ ангилалд хамаарна) болон судлаачийн (докторын түвшинд суралцагчид, эрдэмтэд, салбарын мэргэжилтнүүд энэ ангилалд хамаарна) аль ангилалд оролцохоо тодорхой бичих;

- Дотоодын болон гадаадын их дээд сургуулийн 2 ба түүнээс дээш курсийн оюутан байх;
- Судлаачийн ангилалд оролцогч нь эрхэлж буй ажил албан тушаал, мэргэжлээ тодорхой дурдах;
- Багаар оролцож болох ба гишүүдийн тоо 3-аас ихгүй байна;
- Бүтээлээ заавал 3 хувь хэвлэмэл байдлаар ирүүлэх.

3.3 Бичгийн стандарт:

- Үсгийн фонт- Times New Roman /”Мон” өргөтгөлтэй фонт байж болохгүй/;
- Фонтын хэмжээ – 12;
- Мөр хоорондын зай – 1,5;
- Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;
- Цаасны хэмжээ: А4;
- Товч мэдээлэл: Сэдвийн хүрээнд өөрийн судалгааны хураангуйг бичсэн байх;
- Бусад: Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих;
- Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Илтгэл нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдсэн байх.

ДӨРӨВ.ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Нэгдүгээр шат: Зохион байгуулагчид бүтээлийг хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээн авна.

4.2 Хоёрдугаар шат: Монголбанк болон хөндлөнгийн төлөөлөгч нараас бүрдсэн баг бүтээлийг шүүж нэгдсэн дүнг гаргана.

4.3 Оюутны ангилалд 5 ажлыг хоёрдугаар шатанд сонгон шалгаруулна.

4.4 Судлаачийн ангилалд эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэх бүтээлүүдийг шалгаруулна.

4.5 Эхний шатанд шалгарсан судалгааны ажлуудыг 2024 оны 12 дуаар сарын 23-ны өдрийн 09.00-13 цагийн хооронд хэлэлцүүлнэ.

4.6 Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэхээр шалгарсан бүтээлүүдийн хэлэлцүүлэгт тавигдах шаардлага:

- Илтгэлийг PowerPoint эсвэл PDF файлын хураангуйтай хамт ирүүлэх;
- Илтгэл нь гарчиг, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Илтгэл сэдвийн хүрээнд байгаа эсэх;
- Шинэлэг санаа гаргасан байдал;
- Илтгэх чадвар;
- Санаагаа ойлгомжтой, цэгцтэй хүргэх;
- Асуултад оновчтой хариулж буй байдал;
- Илтгэлийн хугацаа: 10-15 минут.

ТАВ.ТӨЛБӨР

5.1 Оюутны ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, Судалгааны ажлын төлбөр 4,000,000 төгрөг
- 2-р байр - Өргөмжлөл, Судалгааны ажлын төлбөр 3,000,000 төгрөг;
- 3-р байр - Өргөмжлөл, Судалгааны ажлын төлбөр 2,000,000 төгрөг.

5.2 Судлаачийн ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, Судалгааны ажлын төлбөр 7,000,000 төгрөг ;
- 2-р байр - Өргөмжлөл, Судалгааны ажлын төлбөр 5,000,000 төгрөг;
- 3-р байр - Өргөмжлөл, Судалгааны ажлын төлбөр 4,000,000 төгрөг.

ЗУРГАА.МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ

Хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 17:00 цаг хүртэл бүтээлийн хэвлэмэл 3 хувийг Монголбанкны бичиг хэрэгт болон цахим хэлбэрээр [ninbadgar@mongolbank.mn/](mailto:ninbadgar@mongolbank.mn) essay@mongolbank.mn хаягаар хүлээн авна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn веб хуудаснаас болон (976) 11-313210 утсаар лавлана уу.

Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “А” байр
Хууль, эрх зүйн газар
Монголбанк